

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2024 ОНД БАЙГУУЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Орхон аймаг

2024 он

№	Үндэслэж буй бодлогын баримт бичиг	Санхүүжилтийн эх үүсвэр /сая.төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь
3.10. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:							
1	Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх ялангуяа сумын эрүүл мэндийн төвд амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн амны хөндийн үзлэг оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулна.		Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	80,1%	82,8%	Тайлант хугацаанд 90 байгууллагын 16000 хүнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж 1200 хүүхдэд урьдчилан сэргийлэх фторт түрхлэг түрхсэн байна. Үүнд: - “Шүд эрүүл бол бие эрүүл” аяны хүрээнд 39 цэцэрлэгийн эмч арга зүйчийг сургалтад хамруулан тэднээр дамжуулан 27186 багш, эмч, арга зүйч хүүхдийг сургалтад хамруулсан. - “Зөвийг дадал болгоё” аяны хүрээнд шүд угаах дадлыг хэвшүүлэх болзолт уралдаан зарлаж, 19, 12, 24, 26 дугаар цэцэрлэгийн 1200 хүүхдийг хамруулан 1 ангийг шалгаруулан өргөмжлөл үнэ бүхий зүйлээр урамшуулсан. - Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 16 байгууллагын албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын хүрээнд ажлын байранд “Шүд угаах цаг гаргая” аяныг өрнүүлж 70 сургагч багш бэлтгэн 860 албан хаагчид онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. - Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Орхон Политехникийн коллежийн 700 гаруй оюутныг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. - Цахимаар 54 мэдээллийг 25400 хүнд түгээж ажилласан байна. - Боловсролын газартай хамтран сургалт сурталчилгааг зохион байгуулсны дүнд ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага 7 хоногийн 1 өдөр шүд угаах цаг гарган сургалт дадлага хийж хэвшиж байна. Хүүхдийн 37	71,4

						цэцэрлэг “Шүд угаах цаг”-ийг хэвшүүлж, хүүхэд шүдээ зөв угаах дадал хэвшилтэй болж байна. “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 82,1 хувьтай байна.	
2	Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг орон нутгийн түвшинд бусад салбар нэгжийн оролцоог ханган зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.		Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	85%	Тайлант хугацаанд: 26 удаагийн өдөрлөг, аян, форум, 235 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 35899 иргэнийг хамруулж, 55 төрлийн сурталчилгааны материалыг 9471 иргэнд түгээсэн. Боловсролын газартай хамтран 27 ерөнхий боловсролын сургуулийн 1-12 ангийн 1256 бүлгийн багшид сургалт зохион байгуулж 25866 суралцагчид түгээх ажлыг зохион байгуулсан. Сургуулийн өмнөх боловсролын 32 цэцэрлэгийн арга зүйч болон эмчид хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 64 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 2 удаагийн хэвлэлийн бага хурал, 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. Нийгмийн эрүүл мэндийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгаас 26.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдүүлж үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна. “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээний хэрэгжилт 83 хувьтай байна.	90
3	Хэрэгжилтийн хугацаа дуусаж буй дараах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Эрүүл идэвхтэй амьдрал; • Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд; • Хавдрын эсрэг; • Харшлаас сэргийлэх; • Эрүүл чийрэг эр хүн; • Элэг бүтэн Монгол; • Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх; • Орчны эрүүл мэнд. 		Төлөвлөгөөний дундаж хэрэгжилт	88,1%	89%	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 88,4 хувьтай байна. 2024 онд нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нийт 281.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан хэрэгжүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 154 иргэнд 84.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь хавдрын шинээр батлагдсан тохиолдлын 80,2 хувийг эзэлж байна. - Томуу, томуу төст өвчний урьдчилан сэргийлэх болон дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, эмч, эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн хөлсийг шийдвэрлэсэн. - Аймгийн Засаг даргын 2024 оны А/360 дугаар 	70

						<p>захирамжаар орон нутгийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл Эрдэнэт хүн” төслийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн иргэдийг хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5000 хүн, 6,17 настай 4100 хүүхэд буюу 93,8%-тай зүрхний цахилгаан бичлэгт, нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд 30000 гаруй иргэнийг хамруулсан байна.</p> <p>Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 738353 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 260204 хийгдэж, нийт үзлэгийн 35.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар нэмэгдсэн байна. Нийт 235 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 35899 иргэнийг хамруулж, 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн.</p>	
4	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өргөнөөр татан оролцуулах арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулна.		Зохион байгуулсан ажлын тоо	5	6	<p>Тайлант хугацаанд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр 15 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 56 аж ахуйн нэгж, байгууллага, 38605 иргэнийг хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024" өдөрлөгөөр давхардсан тоогоор 765 иргэнд үзлэг хийж, 35 төрлийн гарын авлага зөвлөмжийг 1530 иргэнд түгээн, 4 төрлийн тэмцээнд 70 иргэнийг хамруулсан. - Иргэд олон нийтийг эрүүл мэндийн сургагч багшаар бэлтгэх сургалтад улаан загалмай болон хүүхдийн зөвлөлийн сурагчид, багийн идэвхтэн, оюутан нийт 140 иргэнийг эрүүл мэндийн сургагч багшаар бэлтгэсэн. - “Эрдэнэт” сувилал, "Монос фарм трейд", “Нью верамед” ХХК, хувийн хэвшлийн “Катарсис” клиниктэй хамтран “Би өөртөө хайртай” өдөрлөгт “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2500 ажилтныг хамруулж, сургалт болон нойргүйдлийн богино сорилд хамруулж зөвлөгөө өгч ажилласан. - Дэлхийн гэр бүлийн өдрөөр соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээнд 12 аж ахуйн нэгж байгууллагын 4500 иргэн хамрагдсан. - Амны хөндийн эрүүл мэнд, гарын ариун цэвэр, хүүхдийн хоол тэжээл зэрэг чиглэлээр нөлөөллийн 	100

						<p>арга хэмжээнд 200 хүнийг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Политехник коллежийн 700 гаруй оюутанд эрүүл мэндийн боловсрол олгох өртөөчилсөн сургалт зохион байгуулсан. - Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэгт 63627 буюу нийт хүн амын 59,9 хувь байгаа бөгөөд улсын хэмжээнд 21 аймагтаа хамрагдалтаараа тэргүүлж байна. Үзлэгээр 55077 хүнд зөвлөгөө өгч, 5010 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад авч, 9337 хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлсэн байна. - “Эрүүл Эрдэнэт хүн” төслийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн иргэдийг хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5000 хүн, 6,17 настай 4100 хүүхэд буюу 93,8%-тай зүрхний цахилгаан бичлэгт, нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд 30000 гаруй иргэний хамруулсан байна. 	
5	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг орон нутагтаа бүрдүүлэх, энэ чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, шаардлагатай мэргэжилтнийг улсын төсвийн санхүүжилт (төрийн сан)-аар сургалтад хамруулан гэрээ байгуулж ажиллана		Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийн тоо	7	10	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц дэх Нийгмийн эрүүл мэндийн төвд 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2 мэргэжилтэн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн мэргэжил дээшлүүлэх институтэд 6 сарын мэргэшүүлэх сургалтад, 7 мэргэжилтэн 34 удаагийн зайн болон танхимын сургалтад хамрагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төв болон сургууль цэцэрлэг, албан байгууллагын эмч эрүүл ахуйч сувилагчид 59 удаагийн уулзалт ярилцлага, сургалтад давхардсан тоогоор 2315 хүнд зохион байгуулж шинэ мэдээлэл, арга зүйгээр хангасан.	100
6	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн Эрүүл мэндийн байгууллагын тогтвортой байдлын төлөвлөгөөг орон	Улсын төсөв 36.4 сая Орон	Хариу арга хэмжээний чадавх 95%			Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 02 сарын 21-ны "Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай" А/11 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажилласан. Аймгийн Шуурхай штабын бүрэлдэхүүнд хариуцлагатай жижүүр 24 цагаар ажиллан мэдээллийг шуурхай	100

	нутгийн түвшинд батлан хэрэгжүүлнэ.	нутгийн төсөв 20.0	Нөөц бүрдүүлэлт 91,2%			солилцон ажилласан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 100% тодотгол хийгдсэн. ЭМГ-ын даргын 2024 оны А/64 дүгээр тушаалаар Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн, ажиллах журам, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн харилцаа холбооны урсгалыг шинэчлэн баталсан. Тайлант хугацаанд хоолны хордлого, улаанбурхан, томуугийн хариу арга хэмжээнд тохиолдол удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн хариу арга хэмжээг авч ажилласан Химийн бодисын хордлогыг тандах мэдээлэх, химийн осол хордлогын үеийн эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг үнэлгээг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн төвөөс хийгдэж, мэдээллийн сан үүсгэсэн. Тайлант хугацаанд 1 эмийн хордлого, 6 угаарын хордлого, 1 химийн бодисын хордлогын тохиолдлыг Нийгмийн эрүүл мэндийн төвд мэдээлсэн. Тохиолдол удирдлагын тогтолцооны чадавхыг бэхжүүлэх сургалтад 5 эмч, мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэн, 2 удаагийн сургалтад холбогдох байгууллагуудын 115 хүнийг хамруулан чадавхжуулсан. ЭМГ-ын гамшгийн нөөцөд нэмэлтээр 1 нэр төрлийн 4,8 сая төгрөгийн эм, 5 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн 4,6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл ирсэн нь өмнөх онтой харьцуулахад нөөцийн хангалт 14,27%-аар нэмэгдсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээнд орон нутгаас 20,0 сая зарцуулсан. Эрүүл мэндийн байгууллагууд дунджаар дунджаар 21-30 хоногийн нөөцтэй байна. Гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 95.8%, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 96.5% буюу өмнөх оноос 1,5%-аар нэмэгдсэн.	
7	Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот	Орон нутгийн төсөв 7.0 сая	Халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулсан	95%	100%	Тайлант хугацаанд: - Сүрьеэгийн 5044 үзлэг хийгдсэнээс 3744 буюу 74,2% нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан. Сүрьеэ өвчний 98 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.7 промиллоор өссөн. Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг шинжилгээг	100

	<p>бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ</p>		<p>хувь</p>		<p>зохион байгуулж, 1566 хүн хамрагдахаас 1453 /92,8%/ хамрагдаж, сүрьеэтэй байж болзошгүй 284 /19,5%/ тохиолдлоос холбогдох шинжилгээ авч, 37 тохиолдлыг илрүүлж, эмчилгээнд хамруулсан. Сүрьеэгээс сэргийлэх чиглэлээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 580 ажилтан, их дээд сургуулийн 237 оюутан, эрүүл мэндийн байгууллагуудаар 1500 гаруй иргэнийг сургалтад хамруулсан байна. FM радиод 1, телевизэд 2 удаа мэдээлэл өгч, 2000 гаруй хүнд хүргэсэн. Цахим хуудсаар рийл 1, бичлэг 1, ярилцлага 1 байршуулж, 16726 хүн үзэж, гарын авлага 1000 ширхгийг хэвлэж түгээсэн. Тайлант жилд 7 сая төгрөгийн санхүүжилтээр сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг зохион байгуулан, сүүлийн 2 жилийн үр дүнг Нийгмийн бодлогын хэлтэст танилцуулсан.</p> <p>- Бэлгийн замаар дамжих халдварын кабинетад 4040 хүн үзлэгт хамрагдсанаас 3050/75.4%/ нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. Бэлгийн замаар дамжих халдварын 136 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 12,9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,3 промиллоор өссөн байна. Бэлгийн замаар дамжих халдварын 35.3%-ийг тэмбүү, 16.9%-ийг заг хүйтэн, 47.8%-ийг трихомониаз эзэлж, эмчилгээнд 100% хамрагдсан байна. Жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг тэмбүү, ДОХ-ын халдварыг илрүүлэх шинжилгээнд 100% хамруулж, жирэмсэн тэмбүү 9 оношлогдож хавьтлын хамт эмчилгээнд бүрэн хамрагдсан бөгөөд төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй. Идэвхтэй тандалт эрт илрүүлэгт 689 хүн хамрагдсанаас тэмбүүгийн 4 тохиолдол илэрч эмчилгээнд 100% хамруулсан. Ажлын байранд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх мэдлэг дээшлүүлэх сургалтад согтууруулах ундаа худалдан борлуулдаг 10 аж ахуйн нэгжийн 29 ажилтан, 303 оюутныг хамруулж, ДОХ/ХДХВ/БЗДХ-аас сэргийлэх, оношилгооны аргын талаар 5 төрлийн зурагт хуудас, богино хэмжээний бичлэгийг цахим орчинд байршуулан 6754 хүнд хүргэсэн байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд дэмжээ тэмцээн зохион байгуулж, 24 сургуулийн 192 сурагч оролцсон.</p> <p>Шинээр илэрсэн бүх хэлбэрийн сүрьеэ болон бэлгийн</p>
--	---	--	-------------	--	---

						замаар дамжих халдвартай иргэдийн эмчилгээнд хамрагдалт 100% байна.	
8	Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, авто тээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	47	47	Тайлант хугацаанд сэтгэцийн эрүүл мэнд, осол, гэмтлээс сэргийлэх чиглэлээр 67 үйл ажиллагааг зохион байгуулж, 82685 хүнийг хамруулсан байна. Үүнд: - Эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршил, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 99 зөвлөмж мэдээлэл оруулж давхардсан тоогоор 71356 иргэнд хүргэж, 69 удаагийн сургалтад 14759 оюутан, суралцагчийг хамруулсан - Хүүхдийн 2 зуслангийн сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах ажлыг зохион байгуулж, Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр дэвжээ тэмцээн, "Бидний дунд..." драмын жүжиг тавигдаж урлагаар дамжуулан соён гэгээрүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. - Олон талт эрүүл мэндийн боловсролыг салбар бүрд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх чадавх бүхий иргэд олон нийтийг эрүүл мэндийн сургагч багшаар бэлтгэх 10 багц цагийн сургалтыг улаан загалмай болон хүүхдийн идэвхтэн 87 сурагч, оюутныг сургагч багшаар бэлтгэсэн. - Улаан загалмайн хороотой хамтран "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнийг сургуулийн өмнөх боловсролын 18 байгууллагын 144 хүүхэд оролцож идэвх санаачилга үр дүнгээр манлайлсан 3 байрыг шагнаж урамшуулсан. - "Тамхины ишгүй - Эрдэнэт хот" нөлөөллийн аяны хүрээнд эрүүл мэндийн байгууллага, хүүхдэд үйлчилдэг 6 байгууллага нэгдэн орчныхоо хог хаягдлыг цэвэрлэн #ХоггүйОрчин #ОрхонаймгийнЭрүүлмэндийнгазар тэмдэглэгээг ашиглан хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар сурталчлан ажилласан. - Тамхины хэрэглээний судалгаанд их дээд сургуулийн 302 оюутан, эрэгтэй 176 буюу 58.3%, эмэгтэй 126 буюу 41.7% оюутан хамрагдаж 182 нь электрон болон утаат тамхи татаж үзсэн, татдаг, 120 оюутан татаж үзээгүй. Хорт зуршлын талаар 100% мэдлэгтэй 31 буюу 10.3%, 59 буюу 19.5% нь 60%-с доош мэдлэгтэй байна.	100

9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг мэндийн байгууллагад бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах эрхийг бүрдүүлж ажиллана.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын хувь	85%	85,5%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудын 89%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээ авах гадна болон дотоод тохижилт хийгдэж, өнгөрсөн оноос 4%-аар нэмэгдсэн. - Эрүүл мэндийн байгууллагуудад “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны үндсэн шаардлага” MNS6055:2009 “Явган хүний зам, талбай төлөвлөлт техникийн шаардлага” MNS6808:52019 стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт хийж зөвлөмжийг хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Тус зөвлөмжийн дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүд дуугүй хөтөч, шалны наалт, ханын бариул, томруулагч шил, ариун цэврийн өрөөний ханын бариул зэргийг нэмэгдүүлсэн. - Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2024 оны А/237 тоот захирамж болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Орхон аймгийн салбар зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу “Дохионы хэлний анхан шатны сургалт”-ыг 38 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан зохион багйуулж, гэрчилгээ олгосон. - “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023” стандартын чиглүүлэх 5 удаагийн сургалтад 213 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.	100
10	Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулна.		Сайжруулсан ариун цэврийн байгууламж бүхий эрүүл мэндийн байгууллага	100%	100%	Аймгийн хэмжээнд 176 эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд 100% ариун цэврийн төвлөрсөн усан хангамж, ариутга татуургын системд холбогдсон байна.	100
3.11.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр							
11	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих		“Эрүүл мэндийн үйлчилгээнд	-	80%	Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/18 дугаарт удирдамжийн дагуу 26 эрүүл мэндийн байгууллагад 106 заалтын дагуу үнэлгээ хийхэд MNS	70

	шаардлага" MM8 7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрт хэвшүүлэх, сурталчлах арга хэмжээ хэрэгжүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.		тавих шаардлага" MM8 7014:2023 стандартын хэрэгжилт			7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилт 79.6%-тай үнэлэгдэж, 26 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг нэмэгдүүлж ажилласан. “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023” стандартын чиглүүлэх 5 удаагийн сургалтад 213 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Эрүүл мэндийн цагаан толгой цуврал контентын 14 бичлэгийг Эрүүл мэндийн газрын фэйж хуудаст байршуулж тайлант хугацаанд нийт 27,198 үзэлттэй байна.	
12	Алслагдсан бүс нутаг дахь хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор Багийн эмч нарыг автомашинаар ханган, шатахууны зардлыг шийдвэрлэнэ		Автомашин, шатахууны хангалт	100%	100%	Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 3 багийн эмчтэй, УАЗ фургон, соната-7, мусса маркийн 3 автомашинаар алслагдсан бүс нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж ажилласан. Тайлант хугацаанд тус төв нь гэрийн идэвхтэй хяналт 2395 (28.5%) хийж, 689 гэрийн дуудлага, үүнээс 163 алсын дуудлагад үйлчилсэн байна. Шатахуунд 14,5 сая төгрөг зарцуулсан ба өмнөх онтой харьцуулахад сарын шатахууны хангалт 400,000 төгрөгөөр нэмэгдэж 1.4 сая төгрөг болсон байна. Автомашин, шатахууны хангалт 100% байна.	100
13	Бүх сумдад анхан шатны тусламж, үйлчилгээний мобайл технологийг нэвтрүүлнэ.		Мобайл технологи нэвтэрсэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	3	3	Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөр 3 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологи нэвтрүүлснээр сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 66,7%-д мобайл технологийг нэвтрүүлсэн бөгөөд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	100
14	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллана.		Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хувь	88,3%	89%	Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай” А/122 тоот тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний баг, журам, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн баталсан. Батлагдсан захирамжийг салбарын шуурхай болон өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, ахлагч нарт 2 удаа танилцуулж, мэдээлэл хийсэн. Гэрээний гүйцэтгэлийн хэрэгжилтийг жилд 2 удаа тухайн жилийн 7-р сарын дотор, дараа жилийн 1-р сарын дотор	100

						үнэлэхээр тусгагдсан бөгөөд тайлант хугацаанд эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээ хийсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний дундаж 92,7% болж, өмнөх оны мөн үеэс 5,4%-аар нэмэгдсэн байна.	
15	Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, хяналтын үзлэгийг өргөжүүлэн тусламж, үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.		Гэрийн эргэлтийн хувь	15,2	15,5	Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн идэвхтэй эргэлт 113610 буюу нийт үзлэгт эзлэх хувь 31.9%-тай өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өсөж хийгдсэн гэрийн идэвхтэй эргэлтийн тоо өмнөх оноос 11152 буюу 9.8%-аар нэмэгдсэн байна. Томуу, томуу төст өвчний үед сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн эргэлтийг өргөжүүлж, лавлагаа шатлалын эмнэлэгт хэвтсэн, үзүүлсэн харьяаллын хүүхдүүдийн мэдээллийг авч цахимаар тандалтыг 15,500 хүүхдэд хийсэн байна. Мөн томуу, томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн үед Эрүүл мэндийн газрын тушаалаар жилд 2 удаа сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн зарим тусламж, үйлчилгээг гэрийн эргэлтэд шилжүүлэн анхан шатны тусламж, үйлчилгээний хүлээгдэл чиглэлийг бууруулан ажиллаж байна.	100
16	Орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлнэ.		Тусламж үйлчилгээнд хамрагдсан явуулын иргэдийн тоо	4679	4700	Орон нутгийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл Эрдэнэт хүн” төсөл, хэнийг ч орхигдуулахгүй зарчмын хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн иргэдийг хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5000 хүн, 6,17 настай 4100 хүүхэд буюу 93,8%-тай зүрхний цахилгаан бичлэгт хамруулсан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалгүй 185 иргэн буюу хамруулахаар төлөвлөсөн зорилтот бүлгийн 92,5%-ийг үзлэг шинжилгээнд хамруулсан байна. Мөн 5 удаа эмнэлгийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор эрүүл мэндийн даатгалгүй, малчин, эрсдэлт бүлгийн 2621 хүнд явуулаар хүргэн 7 нэр төрлийн 15 эм, ороох боох материал бүхий 1000 ширхэг малчдын эмийн багцыг түгээсэн байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр эрүүл мэндийн даатгалгүй 68 иргэн тусламж үйлчилгээг авсан байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 7689 түр оршин суугч, явуулын иргэн, зорилтот бүлгийн иргэн тусламж үйлчилгээнд хамрагдсан байна.	100
17	Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 19.3.4		Төсөл саналын	-	1	Орхон аймагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2025-2026 онд нэвтрүүлэх дэвшилтэт технологийн	100

	дэх заалтын дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шинээр нэвтрүүлэх технологийн төсөл, саналыг боловсруулж Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.		тоо			төсөл, саналыг БОЭТ, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр нэгдсэн эмнэлгүүдээс авч эрэмбэлснээс 12 төслийн саналыг ЭМЯ-нд багцалж албан тоотор хүргүүлсэн. Үүнд: перинатологи оношилгооны төвийг байгуулах, цэсний ерөнхий цорго, нойр булчирхайг сэтгүүрдэх ажилбар хийх тоног төхөөрөмж авах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг багаар сургах, аминд аюултай хэм алдагдлын үед түр зуурын пэйсмэйкер тавих мэс заслын дэвшилтэт технологийг орон нутагт нутагшуулах, урологийн тусламж үйлчилгээнд бөөрний чулууг бутлах Holemun Laser лазер аппарат, бөөр шээсний замын уян дурангаар хангагдах, бамбайн зангилаат үүсгэврүүдэд RFA эмчилгээ хийх, зүрхний болон ургийн гажгийн MRI оношилгоо хийх эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ажилчдад химийн хорт бодис илрүүлэх арга аргачлал, шинжилгээг нэвтрүүлэх төслийн саналыг эрэмбэлж хүргүүлсэн. Мөн бүсийн хэмжээнд хавдрын үеийн судсан дотуурх оношилгоо, мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх "Cancer center" байгуулах бэлтгэл ажлыг хангасан.	
18	Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана.		Жирэмсний эрт хяналтын хувь	98,4%	99,5%	Аймгийн хэмжээнд жирэмсний тусламж үйлчилгээг сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв, <u>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн</u> нөхөн үржихүйн нэг цэгийн үйлчилгээний жирэмсний өртөмтгий бүлгийн хяналтын кабинет, төрөх тасаг үзүүлж ажилласан. Тайлант хугацаанд анхан шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудын 92% нь эх баригчийг орон тоогоор дагнан ажиллуулснаар жирэмсний эрсдэлийг илрүүлэх үнэлгээ, жирэмсний нэрийн хяналт сайжирч, лавлагаа шатлалд жирэмсний өртөмтгий бүлгийн кабинетын эмчийн орон тоог 5 болгон нэмэгдүүлснээр жирэмсэн үеийн хүндрэл эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэл солилцох, эмч эмнэлгийн мэргэжилтний ур чадвар нэмэгдэж, жирэмсний хяналт сайжирч 99.4%, өмнөх оноос 1,1 хувиар өссөн байна. Хяналтад байгаа нийт жирэмсний 87,6% нь жирэмсний хэвийн явцтай гэж үнэлэгдэн анхан шатлалд, 12,4% нь жирэмсний өндөр эрсдэлийн улмаас лавлагаа шатлалын эмнэлэгт нарийн мэргэжлийн эмчийн хяналтад хянагдсан. Жирэмсний хяналтад байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.6 хувь	90,9

						цусны шинжилгээнд хамрагдсанаас 33 буюу 2.1 хувь нь цус багадалттай байна. Шинээр хяналтад хамрагдсан 1563 жирэмсэн эмэгтэйн гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээ, ХДХВ, тэмбүүгийн хурдавчилсан сорилд 99.6 хамруулж, трихомониаз 28 буюу 1.8 хувь нь эерэг, тэмбүү 9 буюу 0.6 хувь нь эерэг, заг хүйтэн 3 буюу 0.2 хувь эерэг тус тус гарч, оношийг баталгаажуулан, хавьтагчийн хамт эмчилгээнд 100% хамруулсан байна. Тайлант хугацаанд гепатитын В,С вирусийн халдвартай 20 жирэмсэн эхийг хяналтад авч 17 нярайг 12 цагийн дотор вакцинд хамруулан, 3 нярайд В вирусийн эсрэг иммуноглобулин (НВlg) хийж халдвар дамжихаас сэргийлж ажилласан бөгөөд төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	
19	Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана.		Эхийн эндэгдэл 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлт тутамд/	0 9,4	0 8,4	Тайлант хугацаанд: - Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 4 албан тоот, 5 мэдээлэл, эх, хүүхдийн тусламж үйлчилгээний стандарт, чанар хүртээмжид 4 удаа хяналт хийн зөвлөмж хүргүүлсэн. - Эрүүл мэндийн газрын дэргэдэх Магадлан хэлэлцэх зөвлөл нь 3 удаа хуралдан 2024 онд бүртгэгдсэн амьгүй төрөлтийн 6, гэрийн төрөлтийн 2, нялхсын эндэгдлийн 17 тохиолдолд үзүүлсэн анхан болон 2 дахь шатлалын тусламж үйлчилгээг дүгнэн хэлэлцэж, нөлөөлсөн хожимдлыг тодорхойлж бууруулах, оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлт, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байна. - Амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 16 нярайд сурфактант эмчилгээг хийж, 70 хувийн үр дүн өгсөн байна. - Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг төрсөн 1920 нярайд 100 хувь үзүүлж, нярайн эрт үеийн эндэгдлийг тууштай бууруулж байна. - Жирэмсний хяналт, нярайн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр салбар дундын 2 удаагийн хэлэлцүүлэг, 25 багийн ажлын албатай хамтран 5 хүртэл насны хүүхдийн асаргаа сувилгаа, осол гэмтлээс сэргийлэх сургалт сурталчилгаанд 4245 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулж, ахуйн осол гэмтлээс сэргийлэх 5 төрлийн зөвлөмжийг өгч	50

						<p>ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> - 36 долоо хоногоос дээш хугацаатай 114 эхийг наалдцын шинжилгээнд хамруулж, 65%-ийг эрүүлжүүлсэн. - Нийт 12 удаагийн сургалтыг зохион байгуулж тус сургалтаар давхардсан тоогоор 554 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. - Хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг 3 удаа зохион байгуулж нийт 1023 хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулж зөвлөгөө, мэдээлэл өгсөн. - Хүчирхийлэлд өртсөн 5, жирэмсэлсэн 2 өсвөр насны охидын мэдээллийг ХГБХХГ, БОЭТ-тэй солилцож, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн. <p>Тайлант хугацаанд эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 19 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 10,3 промилл болж өмнөх оны мөн үеэс 0.7 промиллоор өссөн байна.</p>	
20	Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж ажиллана.		9, 18, 36 сартай хүүхдийн хамрагдсан хувь	100%	100%	<p>Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 9,18,36 сартай хүүхдийн үзлэгийг тогтмол зохион байгуулсан бөгөөд тайлант хугацаанд нийт 2100 хүүхэд үзлэгт хамрагдсан бөгөөд 85 хүүхэд хөгжлийн хоцрогдол илэрсэн байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комисс нийт 23 удаа хуралдаж 395 хүүхдийн /сунгалт 220, шинээр 49, хяналтад байгаа болон буцаагдсан 30, цуцлагдсан 17/ асуудлыг шийдвэрлэж, сургуулийн өмнөх боловсролд 2, ерөнхий боловсролын сургуульд 3, тусгай хэрэгцээт хүүхдийн сургуульд 2, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 14 бусад нийгмийн хамгааллын үйлчилгээнд 8 хүүхдийг тус тус хамруулсан байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын гишүүд бага насны хүүхдийн хөгжлийн цогц үзлэг, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх практик сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2024 онд шинээр ажилд орсон 22 эмч, сувилагчийг хамруулсан.</p> <p>Тайлант хугацаанд 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдалт 100% байна.</p>	100

21	Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.		Дэмжлэг үзүүлсэн тоо /тохиолдол бүрт/	2	тохиолдол бүрт	Тайлант хугацаанд жирэмсэн эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдлыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зардлаар тээвэрлэн хүргэж, дээрх 2 эхийн амь нас аврагдсан байна.	100
22	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Ангиографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана	Орон нутгийн төсөв 419.9	Ашиглалтын хувь	100%	100%	- Компьютер томографын аппарат, ангиографийн аппарат, хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаанд хуваарийн дагуу үзлэг хяналт тогтмол тавьж ажилласан. Тайлант хугацаанд БОЭТ-ийн эмнэлгийн тоног төхөөрөмжид гарсан гэмтэлд 419.9 сая төгрөгийн төсвийг зарцуулсан бөгөөд ангиографийн аппаратын эд анги солих засвар үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 400,0 сая төгрөг, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрт хугацаат сэлбэг хэрэгсэл, тос тосолгооны материалд 19,9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна - БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн алба нь тоног төхөөрөмжийн 3 инженертэй бөгөөд тайлант хугацаанд засвар үйлчилгээний 301 дуудлага ирж үйлчилснээс хэвийн үйл ажиллагаанд оруулсан 158 багаж тоног төхөөрөмж байна. - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй гэрээ байгуулж инженер техник ашиглалтын аюулгүй ажиллагааны заавраар хангаж, урьдчилан сэргийлэх үзлэг, урсгал засвар, техникийн завсар үйлчилгээ хийж, газардуулга, хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмжид хяналт хийж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүдийн ашиглалт 100% байна.	100
23	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн		Тогтоосон хугацаанд хүргүүлсэн тооцоо, судалгааны	100%	100%	Tender.gov.mn сайтаар ажил үйлчилгээ, бараа худалдан авч ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 61 багцад 5,5 тэрбум төгрөгийн төсөв бүхий худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд 1 багцын худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 2 багцад үнийн санал авсан, 58	100

	байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, судалгааг гарган Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.		хувь			багцад 29 компани шалгаран гэрээ байгуулан сар тутам тогтмол, тасалдалгүй нийлүүлж ажилласан. Тайлант хугацаанд 5.28 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бусад шаардлагатай барааг авч ажилласан. Мөн Ерөнхий гэрээгээр 20 компанитай 85 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийг нийт төсөвт өртөг 1,5 тэрбум төгрөг байгаа бөгөөд одоогийн байдлаар 1,072 саяд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл авч ажилласан. Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг мөн төрийн өмчид шилжсэнээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж 42 багцын эм, эмнэлгийн хэрэгсэл, тодосгогч бодисын авах нийт төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөг, үүнээс 22 багцад тендер шалгаран гэрээ байгуулан ажилласан. Мөн ерөнхий гэрээгээр 15 компанитай 45 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийн 233 сая төгрөгийн гэрээ байгуулснаар 218 сая төгрөгийн буюу 93,5%-тай худалдан авалт хийсэн байна. Нийт худалдан авалтын гэрээ байгуулсан компаниудын нийлүүлэлт 92,0%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,2%-аар гэрээний хэрэгжилт сайжирсан байна. Тус цахим сайтад тендерийн худалдан авах үйл ажиллагааны бүх мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.	
24	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн төсөв 8.0 сая	Цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамж	100%	100%	Аймгийн Засаг даргын 2024 оны А/229 дугаар захирамжаар 8,0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулсан. Суурин цус цуглуулалтаар 562 донороос 562 нэгж цус, шинэ 140 донороос 140 нэгж цус цуглуулсан. Цусны салбар төвд бүртгэлтэй 562 донорт цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг хийж 100% баталгаажуулсан ба резус эерэг 560, сөрөг 2 донор бүртгэгдсэн. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх тусламж үйлчилгээний бэлэн байдлыг үнэлэх чиглэлээр 67 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд 1152 нэгж цус цусан бүтээгдэхүүн	100

						үйлдвэрлэснээс 908 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг зарцуулсан байна. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэл 2 бүртгэгдсэн. Цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна.	
25	Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ		Шийдвэрийн тоо /тухай бүрт/	1	/тухай бүрт/	Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлаар тусгай зөвшөөрлийг 1 дотор, 1 сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх клиникт шинээр олгосон. Бүсийн оношилгоо эмчилгээний Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн аймгийн Засаг даргын захирамжаар эмч нарын цалин болон шатахууны зардалд 285 сая төгрөгийг шийдвэрлүүлэн ажилласан. Улсын төсвөөс Цагаанчулуут багт өрхийн эрүүл мэндийн төвийн барилгад 1.8 тэрбум төгрөг батлагдсан. Жаргалант сумын эрүүл мэндийн төвд граж, моргийн барилгын тендер зарлагдан гэрээ байгуулсан ба 2025 онд барилгын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.	100
3.12.Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр							
26	Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно.		Өндөр хурдны интернэт сүлжээнд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын хувь			Тайлант хугацаанд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад цахим эрүүл мэндийн info.mn, health.gov.mn системээр амбулаторийн үзлэг, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, эмнэлгийн хуудсыг цахимаар олгох, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ, сэргээн засах, гэрийн эмчилгээний бүртгэлийг хийж, программ хангамжийн дэд бүтцийг сайжруулсан. Аймгийн Засаг даргын тамгын газраас хэрэгжүүлж буй “Цахим Эрдэнэт-1” хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагын техник хангамжийн дэд бүтцийг сайжруулж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20 ширхэг зөөврийн компьютероор хангаж, түргэн тусламж, гэрийн эргэлт дуудлагаар очиж үзсэн эмч өвчтөний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэлийг хийх, хөнгөлөлттэй эмийн жор бичих зэрэг цахим бүртгэлтэй холбоотой ажиллагааг газар дээр нь хийх боломж бүрдсэн. Хувийн хэвшлийн ор бүхий клиникүүд, өрхийн эрүүл мэндийн төвүүд dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернэтийн сүлжээнд 100% холбогдож, сүлжээний дэд бүтцийг сайжруулсан.	100

27	<p>Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлэн техник тоног төхөөрөмжөөр хангана.</p>		<p>Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийн хангалтын хувь</p>	33%	33,5%	<p>Тайлант хугацаанд телемедицинский хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 215 хүний мэдээллийг оруулсан. - БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсан бөгөөд 2024 онд нийт 21 өвчтөнд зөвлөгөө авсан байна. - Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн. - Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан. - "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20 ширхэг таблетаар хангаж, түргэн тусламж, гэрийн эргэлт дуудлагаар очиж үзсэн эмч өвчтөний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэлийг хийх, хөнгөлөлттэй эмийн жор бичих зэрэг цахим бүртгэлтэй холбоотой ажиллагааг газар дээр нь хийх боломж бүрдсэн. - Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи хэрэгжиж тайлант хугацаанд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт ашиглаж давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. <p>Тайлант хугацаанд 50 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна. Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийн хангалт 33.2%-тай болж өмнөх оноос 0,2%-аар нэмэгдсэн байна</p>	100
28	<p>Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь</p>		<p>Шаардлагатай сервер, тоног</p>	100%	100%	<p>Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газрын мэдээллийн систем, цахим хуудасны сервер,</p>	100

	заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж ажиллана.		төхөөрөмжийн хангалт			албан ажлын хэрэгцээнд төрийн байгууллагын цахим шуудангийн үйлчилгээг Үндэсний дата төвийн төв серверт байршуулан, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шаардлагатай сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иж бүрэн Firewall сервер, сүлжээний төхөөрөмжүүд, IP камер, windows surface tablet зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч суурилуулан ашиглаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай багц хуулиудын сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдэд 2 удаа, эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо сургалтууд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 789 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. ЦХХХЯ, ЭМЯ-наас зохион байгуулсан “Цахимд хэвшье-Digital first”, “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” 2 удаагийн сургалтад эрүүл мэндийн байгууллагын 800 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, эрүүл мэндийн цахим шилжилт, мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдсан. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын стандарт журмын хэрэгжилт 83%, шаардлагатай сервер, тоног төхөөрөмжийн хангалт 100% байна.	
29	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.		Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	-	1	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газраас Орхон аймаг дахь Тагнуулын газарт Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр хүсэлтээ албан бичгээр уламжилсан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэх чиглэлээр албан тоотыг хүргүүлсэн. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв тус эрсдэлийн үнэлгээг хийлгэсэн байна.	100
3.13.Хүний нөөцийн чиглэлээр							
30	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутаг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон		Орон сууц, гэрээр хангагдсан эрүүл мэндийн	14	10	Тайлант хугацаанд түрээсийн орон сууцаар 7, гэрээр 1 эрүүл мэндийн ажилтан хангагдаж, 3 ажилтанд орон сууцны дэмжлэгт 39.0 сая төгрөг олгогдсон байна. Үүнд: - Эрдэнэт сувиллын цогцолбор нь орон сууц худалдан авсан 3 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг	100

	сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.		ажилтны тоо			<p>үзүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн ажилтны гэр гал түймэрт өртсөн тул 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. - Улаанбаатараас “Анхны-Оч” өрхийн эрүүл мэндийн төвд шилжин ажиллаж байгаа 1 эмчийн гэр бүлийг 2 өрөө түрээсийн орон сууцаар хангасан. - Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 6 албан хаагч түрээсийн орон сууцанд хамрагдсан байна. 	
31	Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.		Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	13,6%	14%	<p>2023-2024 онд улсын төсвийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 82 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн санхүүжилтээр 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 3,2% нь суралцсан. Төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92% байна. ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах" төслийн хүрээнд 2023-2024 онд буюу 6 дахь жилийн сургалтад "Яаралтай тусламжийн сувилахуй"-аар 2 сувилагч элсэн суралцаж байна. Тус төслийн хүрээнд "Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр", "Эмнэл зүйн шатлал"-ийн хөтөлбөрийг Орхон аймагт улсын хэмжээнд анх удаа эхлүүлэн, хөтөлбөрийн хүрээнд хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулж, 12 шинэ сувилагчийг хөтөлбөрийн дагуу ажлын байранд нь дадлагажуулсан. Тус хугацаанд 1412 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдсан нь нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 91%ийг эзэлж байна. Мөн 126 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна. Мөн гадаад сургалтад багийн бага эмч 3, сувилагч 3, эмч 4, удирдах ажилтан 4 нийт 14 ажилтан хамрагдсан. Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14% болж, өмнөх оноос 0,9%-аар нэмэгдсэн.</p>	100
3.14.Бусад үйл ажиллагааны чиглэлээр:							
32	Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад		Орон нутгийн хөрөнгө	2.8		Тайлант хугацаанд БОЭТ-ийн амбулатори болон төрөх тасагт 500,0 сая төгрөгийн эмэгтэйчүүдийн суурин	100

	зайлшгүй шаардлагатай (түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээний зардал) бусад дэмжлэгийг (Багийн эмчийн унааны шатахууны зардал) Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.		оруулалт Улсын төсөв	тэрбум 3.8 тэрбум		болон зөөврийн эхо аппарат, 129,6 сая төгрөгийн чих хамар хоолойн үзлэг болон төвөнхийн харалтын иж бүрэн дуран, 150,0 сая төгрөгийн ургийн гажгийг эрт оношлох ЭХО тоног төхөөрөмжүүд бүрэн нийлүүлэгдэн ашиглагдаж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр 276.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс орон нутгийн төсөв 163.7 сая (59,2%), төсөл хөтөлбөр 112.7 сая (40,8%) төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Барилга, их засварт: - Улсын төсвөөс Бүсийн оношилгоо эмчилгээний төвд мэс заслын Вакум хагалгааны өрөөний их засварт 1.4 тэрбум, Цагаан чулуут багт Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга 1.8 тэрбум төгрөг тус тус батлагдан БОЭТ-ийн Мэс заслын вакум хагалгааны өрөөг байгуулан засварлаж байна. - Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын нэгдсэн тасагт 533.3 сая төгрөг, Гэмтлийн тасгийн их засварт 305.2 сая төгрөг, эмчилгээний хоолны тасгийн дээврийн засварт 44,0 сая төгрөгийн нийт 882.5 сая төгрөгийн их засварын ажлууд хийгдсэн. - Орон нутгийн төсвийн 253.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны Оч өрхийн эрүүл мэндийн төвийн дээврийн болон дотор засвар, Баян-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор Мөнхийн Гэгээ өрхийн эрүүл мэндийн төвд 24.8 сая төгрөгийн дээврийн завсар, Жаргалант сумын ИТХ-ын тогтоолоор Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 356.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн.	
33	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг		Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын тоо	275	342	- 2024 оны төлөвлөгөөнд нийт 47 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөснөөс 100 хувь хамруулж ажилласан. Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын хууль сахин мөрдөлтийн хувь 80,4, эрсдэл үүсэх магадлал 22 хувьтай үнэлэгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 495 зөрчлийг илрүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 479 заалттай, 42 албан шаардлага, 35 заалттай 5 зөвлөмжийг хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилт 78 хувьтай	100

	бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана					<p>хангагдсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуй нэгжийн өргөдөл, гомдлоор нийт 7 объектод хийсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь барагдуулж ажилласан байна. - Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжуудын хүрээнд нийт 288 объектод хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар 182 зөрчлийг илрүүлж, 85 зөрчил буюу 46,7 хувийг газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 88 дүгнэлт, 62 зөвлөмж, 15 албан шаардлагыг хүргүүлэн ажилласан. <p>Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар зөрчил үйлдсэн нь тогтоогдсон 10 иргэн, 7 аж, ахуй нэгж байгууллагад “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу нийт 17.0 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсныг 100 хувь барагдуулж, 841,000 төгрөгийн нөхөн төлбөрийг тогтоон бүрэн барагдуулсан байна.</p>	
34	Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана.		Нөөц эх үүсвэрийн бэлэн байдлын хувь	90%	91%	<p>Цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төв 110 кватт-ын чадалтай 2 нөөц цахилгаан үүсгүүртэй бөгөөд 3 блокийн 13 тасаг нэгжийг аваарын үед цахилгаан тэжээлээр ханган ажилласан. Тайлант хугацаанд 12 удаа цахилгаан тэжээл тасарсан үед нөөц цахилгаан үүсгэвэр нийт 234 минут ажилласан байна. - Мэргэжлийн байгууллагаар 4 удаа шалгалт тохируулга хийлгэж, 3 удаа ажиллагааны шалгалт хийсэн. - Ажлын байран дахь аюулгүй ажиллагааны чиглэлээр тасаг нэгжийн 42 ажилтныг хамруулан сургалт зохион байгуулсан. - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр хагалгаа, мэс заслын тоног төхөөрөмжүүдийг өдөр бүр шалгалт тохируулга хийж тэмдэглэл хөтөлсөн. - Эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өвчтөнүүдийн байнга харьцаж болох цахилгаан хэрэгслүүдэд өдөр тутмын хяналт хийж ажилласан. - Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 	100

						<p>Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлгүүд 110 кВ цахилгааны эх үүсгэвэртэй, цахилгаан саатлын үед 24-48 цаг ажиллах боломжтой ба шатахуунаар цэнэглэн хэвийн ажиллах хүчин боломж бүрдсэн.</p> <p>- Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 10 цахилгааны эх үүсгэвэр байна.</p> <p>Нөөц эх үүсвэрийн бэлэн байдал 91,5%-тай болж, өмнөх оноос 1,5%-аар нэмэгдсэн байна</p>	
35	Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламж, олон улсын байгууллагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, дэмжлэг туслалцаа үзүүлнэ.		Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	96,7%	96,8%	<p>Тайлант хугацаанд олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд:</p> <p>- Азийн Хөгжлийн банкны МОН-9218 төслийн хүрээнд 13.7 сая төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн 54 ширхэг тоног төхөөрөмжийг БОЭТ, сум, өрхийн дархлаажуулалтын 10 нэгжид олгосон.</p> <p>- Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд нүдний улаан рефлекс шалгах 15 ширхэг Arclite багажаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хангагдсан.</p> <p>- Дезерет олон улсын байгууллагаас сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 99.0 сая төгрөгийн нярайн шарлагын аппарат болон бусад техник хэрэгслээр хангагдан ашиглалт 100% байна.</p>	100
36	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана.		Нэвтрүүлсэн сайн туршлага	5	5	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 4 төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл болон үйл ажиллагааг мэдээллийн самбар болон цахим хуудсаар сурталчлан, дэмжин хамтран ажилласан.</p> <p>Тухайлбал:</p> <p>- Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн сайн дурын 2 идэвхтэнтэй хамтарч сүрьеэ өвчнөөр эмчлэгдэж байгаа 6 иргэний эмийг хяналттай уулгасан. Мөн тус нийгэмлэгээс зорилтот бүлгийн 6 иргэнд аминдэм болон хүнсний тусламж олгосон байна. Эмзэг бүлгийн сүрьеэтэй иргэдийн нийгмийн халамж дэмжлэгт хамрагдсан хувь 17,1% байна.</p> <p>- Аймгийн явган алхалтын холбоотой хамтран “Энэ жилдээ эрүүл жиндээ” явган алхалтыг 2 удаа зохион байгуулж 1000 гаруй хүн хамруулж, “Орхон 100 км” улсын хэмжээний алхалтад хамрагдах 200 иргэнд эрүүл мэндийн байгууллагаас 5 сая төгрөгийн үнэ бүхий аминдэмийн багцаар дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Архидалт мансуурлын эсрэг ассоциацийн архинаас</p>	100

						<p>татгалзах сэдэл төрүүлэх, сайн туршлага хуваалцах нөлөөллийн ажилд давхардсан тоогоор 925 иргэн хамрагдсан.</p> <p>- Аймгийн Ахмадын хороотой хамтран настны эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Үүргэвчтэй аялал”, “Эрүүл мэнд. Эко гороо аялал”, ахмадуудын дунд спортын 3 төрөлт тэмцээн зэргийг зохион байгуулж 500 гаруй ахмадыг хамруулсан байна.</p> <p>- “Ариун саруул бат”, “Сэтгэлзүйн цогц боловсролын төв” зэрэг 2 төрийн бус байгууллагатай хамтран 2 үйл ажиллагаа зохион байгуулж 3000 гаруй хүнд сургалт болон сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p>	
4.Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт							
37	Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ		Хүсэлтийн тоо	1	Тухай бүр	Байгууллагын хувьд 2023 оны жилийн эцэст 1071,0 мянга төгрөгийн авлага, 575,1 мянган төгрөгийн өр төлбөрийг Сангийн яамтай хоорондын тооцоогоор нийлэн өр, авлагыг баталгаажуулсан. 2024 оны 04 сард Сангийн яамнаас 1071,0 мянган төгрөгийн авлага бүрэн төлөгдөж 575,1 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан. 2024 оны 10 сарын байдлаар байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотойгоор 8,1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн бөгөөд уг өр төлбөрийг Сангийн Сайдын 73-р журмын дагуу зардлын бүлэг хооронд шилжүүлэх саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, 11 сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж шийдвэрлүүлэхээр холбогдох баримт материал, албан бичгийг хүргүүлсэн.	100
38	Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна		Давхцал үүсгээгүй байх	0	0	2023 онд аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулсан хөрөнгө оруулалтыг дараа оны буюу 2024 оны улсын төсөвт тухайн төсвийн төслийг оруулахдаа хөрөнгө оруулалтыг ангилан эрэмбэлж давхцал үүсгэхгүйгээр улсын болон орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын саналуудыг эрэмбэлэн гаргаж албан тоотоор хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.	100
39	Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4		Өр авлагагүй ажилласан байдал	-	-	Эрүүл мэндийн салбар байгууллагын хувьд 2023 оны жилийн эцэст нийт 5,2 тэрбум төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага, нийт 4,1 тэрбум төгрөгийн өр төлбөрийг тайлагнаснаас ажилчин албан хаагчидтай холбоотой	70

	болон 16.5.2, 16.5.3,16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.					504,3 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний өр төлбөр 2,2 тэрбум, байгууллагад төлбөр өглөг 1,3 тэрбум байгаагаас 2024 оны байдлаар нийт авлагыг 4,7 тэрбум буюу 90,3%-аар бууруулан 500,1 сая төгрөгийн авлагатай үлдэгдэлтэй байна. Өр төлбөрийн хувьд ажилчин албан хаагчидтай холбоотой үүссэн байсан 504,3 сая төгрөгийн өр төлбөрөөс 218,5 сая төгрөг буюу 43,3%-аар өглөгийг бууруулсан. Бусад эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, бараа ажил үйлчилгээний нийт өглөг 2024 оны эхнээс 0,3 тэрбум төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт хугацаандаа орж ирэхгүй сар дамжин олгогдож байгаагаас шалтгаалан өр төлбөр хуримтлагдсантай холбоотой байна.	
40	Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ		Тайлан хугацаанд хүргүүлсэн хувь	100%	100%	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамаарах орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитаар хянан баталгаажуулан Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нэгдсэн тайланг гарган Эрүүл мэндийн Сайдаас ирсэн албан хуваарийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 14-21-ны өдрүүдэд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэл тайланд бүрэн нэгтгүүлж ажилласан. Нэгтгэл тайланд байгууллага тус бүрээр холбогдох анхан шатны баримт материалуудыг авч хадгаламжийн нэгж хэлбэрээр хүлээлгэн өгсөн.	100
41	Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ.		Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлсэн тоо	Тухай бүр	Тухай бүр	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын багцад 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр барих барилга тусгагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас тендер зарлагдана.	70
42	Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны дотор хүргүүлж байна		Эрх шилжсэн үйл ажиллагааны тоо	-	-	Эрүүл мэндийн яамнаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт хийгдээгүй.	-

43	Хэрэгжүүлэгч нь хагас жилээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг 06 дугаар сарын 15-ны дотор; бүтэн жилээр гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.		Хугацаанд нь биелэлт хүргүүлсэн хувь	100%	100%	Тус гэрээний биелэлтийг 2024 оны эхний хагас жилээр Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтээр тайлагнаж, аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 89,2%-тай үнэлэгдэж, ЭМЯ-нд албан тоотоор хүргүүлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар гэрээний заалт бүрээр, гэрээний хавсралтын дагуу иж бүрэн хугацаанд нь тайланг нэгтгэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг 2024 оны 11 сарын байдлаар гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.	100
Хэрэгжилтийн дундаж хувь 95,3%							

ХЯНАЛТ –ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2023 он	Хүрэх түвшин 2024 он	Хүрсэн түвшин 2024.11	Тайлбар	Хэрэгжилтийн хувь
1.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	77.1	57.1	94.3	Артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 50697 хүн хамруулахаар 47812 /94.3%/ хүн хамрагдаж өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн.	100
2.	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	68.1	64.4	86.8	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 50697 хүн хамруулахаар 44005 хүн хамрагдаж 86.8 хувьтай байна.	100
3.	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	13943	13584	18704	Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-60 насны 20612 эмэгтэйг хамруулахаар төлөвлөснөөс 18704 буюу 90.7 хувийг хамруулж, өмнөх оны мөн үеэс 4085 хүнээр өссөн.	100
4.	Умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	37.1	38.1	93.4	Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 3708 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 93.4 хувийг эзэлж байна.	100
5.	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдалтын хувь	41.9	70.0	59.9	Тайлант хугацаанд улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэгт 63627 буюу нийт хүн амын 59,9 хувь байгаа бөгөөд улсын хэмжээнд 21 аймагтаа хамрагдалтаараа тэргүүлж байна	64.3
6.	В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	99.7	99.8	99.3	В вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгад 1839 хүүхэд хамрагдахаас 1827 хүүхэд хамрагдаж хамралтын хувь 99.3 хувьтай, 12 хүүхэд өвчний улмаас түр хойшилсон байна.	99,5
7.	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит хемофилүсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	99.8	99.9	99.8	Тавт вакцинд 1545 хүүхэд хамрагдахаас 1542 хамрагдаж хамралтын хувь 99.81 хувь байна.	99,8
8.	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	99.5	99.6	100	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгад 1804 хүүхэд хамрагдахаас 1804 хамрагдаж хамралтын хувь 100 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар нэмэгдсэн.	100

9.	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	0.0	0.0	0.0	Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй.	100
10.	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	8.1	7.1	9.8	Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 9.8 промилл, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.6 промиллоор өссөн байна.	0
11.	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	5.4	4.4	8.2	Нярайн эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 8.2 промилл байна.	0
12.	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	9.4	8.4	10.2	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 0.4 промиллоор буурсан.	0
13.	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	4.0	3.0	3.3	Амьгүй төрөлтийн 6 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 нийт төрөлтөд 3.3 промилл байна. Өнгөрсөн оны мөн үеэс 1 промиллоор буурсан.	70
14.	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	98.5	99.5	99.4	Жирэмсний хяналтад шинээр 1563 эмэгтэйчүүд хамрагдсан ба эхний 3 сартайд 1553 хүн хяналтад орсон нь өмнөх оноос 1.1 хувиар өссөн.	100
15.	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	6.4	5.4	6.2	Өсвөр насны охидын төрөлтийн 55 тохиолдол бүртгэгдэж 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин 6.2 промилл байна.	20
16.	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	6.0	5.0	9.3	Сүрьеэ өвчний 98 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 39 тохиолдол буюу 3.7 промиллоор өссөн.	0
17.	Вируст гепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	0.7	0.4	0.4	Вируст гепатит өвчний 4 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор бага үзүүлэлттэй байна.	100
18.	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	19.9	18.4	16.2	Зүрх судасны өвчлөлөөр нас барсан 171 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 16,2 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 16 тохиолдлоор буюу 1.4 промиллоор буурсан байна.	100
19.	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	11.6	10.6	13.3	Хорт хавдрын улмаас нас барсан 140 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 26 тохиолдлоор буюу 2.6 промиллоор өссөн.	0
20.	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0.5	0.3	0.3	Амиа хорлож нас барсан тохиолдол 3 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор буюу 0.2 промиллоор буурсан.	100
21.	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /Х40-Х49/	1.3	1.0	0.3	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын 16 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0,3 промилл байна.	100

22.	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10 000 хүүхдэд, Т20-Т32)	18.5	17.5	10.3	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн 11 тохиолдол бүртгэгдэж 10000 хүүхдэд 10.3 промилл, өнгөрсөн оны мөн үеэс 6.4 промиллоор буурсан.	100
23.	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99)	0.0	0.0	0.2	Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэний 1 тохиолдол нь 0-18 нас хүртэлх насны хүүхэд байсан ба 10000 хүүхдэд 0.2 промилл байна.	50
Хэрэгжилтийн дундаж хувь 66.9%						

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ИТГЭЛ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ